



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 01

Арвайхээр

**Г Орон нутгийн үйлдвэрлэгчдийг худалдан
авалтаар дэмжих тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1}, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоол, 2019 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.22 дахь заалтыг хэрэгжүүлэх, зорилтот жилийн хүрээнд орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг төрийн байгууллагуудын худалдан авалтаар дэмжих зорилгоор ДААЛГАХ нь:

1. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт;

1.1. Байгууллагын албан хэрэгцээнд орон нутагт үйлдвэрлэгдэж байгаа дор дурдсан бүтээгдэхүүнүүдээс худалдан авах. Үүнд:

1.1.1. Хэвлэмэл бүтээгдэхүүн:

- а. Ном товхимол, гарын авлага, сургалтын материал;
- б. Сонин, сэтгүүл, тогтмол хэвлэл;
- в. Хуанли, ил захидал, баярын мэндчилгээ, урилга танилцуулга, ухуулга сурталчилгааны хуудас;
- г. Албан бланк, дугтуй, төсвийн байгууллагын бүх төрлийн хэвлэмэл материал;
- д. Газрын зураг, хулдаасан хэвлэл, хаяг, самбар, анонс;
- е. Бусад хэвлэмэл бүтээгдэхүүн;
- ж. Бүх төрлийн бэлэг дурсгалын зүйлс

1.1.2. Ноосон болон оёмол бүтээгдэхүүн:

- а. Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;
- б. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн дүрэмт хувцас;
- в. Спортын хувцас, өмсгөл;
- г. Машины хучлага, ачааны бүтээлэг, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зөөлөн эдлэл;
- д. Гэрийн эсгий болон брезентэн дээвэр, туурга, дотуур, гадуур цагаан бүрээс, хөшиг, ноосон болон эсгий гудас, хөнжил;
- е. Нэхмэл, сүлжмэл болон эсгий улавч, шаахай;
- ж. Бусад төрлийн оёмол болон эсгий бүтээгдэхүүн;

1.1.3. Хүнсний бүтээгдэхүүн

- а. Мах, махан бүтээгдэхүүн;
- б. Сүү, цагаан идээ, сүүн бүтээгдэхүүн;
- в. Савласан ус, эрдэст ус, рашаан;
- г. Гурилан бүтээгдэхүүн;

011200001

д. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ.

1.1.4. Бусад төрлийн бүтээгдэхүүн:

- а. Бүх төрлийн ширээ, сандал, тавилга, хувин сав, сийлбэр бэлэг дурсгал;
- б. Барилгын гадна, дотор хаалга;
- в. Бүх төрлийн модон эдлэл, тавилга, модлог шахмал хавтангаар хийсэн тавилга;
- г. Монгол гэр, гэрийн мод;
- д. Барилгын хуванцар цонх, хаалга;
- е. Бүх төрлийн тоосго, блок, хавтан, бетон зуурмаг, хар замаска;
- ж. Зам, талбайн хавтан, бетонон хашлага, төмөр хайс;
- з. Шахмал түлш;
- и. Багсармал болон ногоон тэжээл;
- к. Бусад бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ.

2. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт;

2.1. Энэхүү албан даалгаврын 1 дэх заалтад тусгагдсан бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн судалгааг гарган 2020 оны 03 дугаар сарын 12-ны дотор сум, байгууллагуудад хүргүүлэх

2.2. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, чадавхжуулах зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг, үзэсгэлэн худалдааг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах

2.3. Орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч дотоодын үйлдвэрлэлээ дэмжих уриалга гаргах, олон нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж, үр дүн тооцож тайланг сар бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлэх

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт;

3.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих автозам, барилга угсралт, засварын ажлуудын тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахдаа орон нутагт үйлдвэрлэсэн барилгын материал, ажиллах хүч авах талаар заалт тусган хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн гаргах

4. Албан даалгаврын хэрэгжилтийг байгууллага бүр сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээний хамт гарган харьяа төрийн сандаа нэгтгүүлж байхыг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт, нэгтгэсэн дүн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг сумдын Санхүүгийн албанд, албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй байгууллагын дарга, эрхлэгч нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг зорилтот жилийн Ажлын хорооны дарга (Ц.Ганболд)-д тус тус үүрэг болгосугай.

5. Бараа бүтээгдэхүүнийхээ чанар, стандартыг сайжруулах, нэр төрөл, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллахыг нийт үйлдвэр эрхлэгчдэд, орон нутгийн үйлдвэрлэлээ худалдан авалтаар дэмжихийг иргэн, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдад тус тус уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД